



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 24 (161)

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг:

- *Зарил шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай*

Монгол Улсын Засгийн газрын тогтоол:

- *Тогтоолуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Хөтөлбөр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

**Улаанбаатар хот
2000 он**



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны зургадугаар сарын 28 № 24 (161)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

253. Зарим шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай

Дугаар 89 457

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

254. Нэрэмжит болгох тухай Дугаар 69 465

255. Малын гоц халдварт өвчний цагийн байдалтай
холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Дугаар 70 466

256. Тогтоолуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 71 468

257. Хөгөлбөр батлах тухай Дугаар 72 468

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 6 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 89

Улаанбаатар
хот

Зарим шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Нямдоржийн Ичинхорлоог Архангай аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчийн,

Пүрэвсүрэнгийн Батсайханыг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 5 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар
хот

НЭРЭМЖИТ БОЛГОХ ТУХАЙ

Гэгээрлийн сайд, Батлан хамгаалахын сайдын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсын анхны маршал Гэлэгдоржийн Дэмидийн мэндэлсний 100 жилийн ойг тохиолдуулан

Зэвсэгт хүчний 186 дугаар анги, Архангай аймгийн Ихтамир сумын арван жилийн дунд сургуулийг тус тус түүний нэрэмжит болгосугай.

**Монгол Улсын Ерөнхий
сайд**

Р.АМАРЖАРГАЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 5 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар
хот

**Малын гоц халдварт өвчний
цагийн байдалтай холбогдуулан
авах зарим арга хэмжээний тухай**

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт гарсан малын гоц халдварт А010 өвчний цагийн байдал, зарим аймагт хийсэн мал эмнэлгийн үзлэгийн дүн, мал вакцинжуулалтын ажлын явцыг харгалзан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн Улаанбадрах, Хөвсгөлөөс бусад сумдын иргэний хамгаалалтын бүх нийтийн бэлэн байдлын зэргийг иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг болгон өөрчилж, хорио цээрийн хязгаарлалтын бүсийн дэглэмээр ажиллуулахаар тогтоосугай.

2.Дорнод, Сүхбаатар, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Хэнтий, Төв, Сэлэнгэ, Дархан-уул, Орхон, Булган аймгийн нутаг дэвсгэрийг иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн болон хорио цээр тогтоосныг 2000 оны 5 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн цуцалсугай.

3.Дорноговь аймгийн нутгаар дайран өнгөрөх авто болон төмөр замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хорио цээрийн дэглэмийг сахиулах шаардлагын дагуу зохицуулан зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүү, хил, гааль болон мэргэжлийн хяналтын байгууллагын эрх баригчид, Дорноговь аймгийн Засаг дарга Л.Ишдоржид тус тус даалгасугай.

4.Хорио цээр цуцлах хүртэл хугацаанд Дорноговь аймгийн нутаг дэвсгэрээс мал, амьтны гаралтай түүхий эд гаргах, худалдан борлуулахыг хориглосугай.

5.Улаанбадрах, Хөвсгөл сумын нутаг дэвсгэрт тогтоосон хорио цээрийн дэглэмийг мөрдөн ажиллах, харуул хамгаалалт, хяналтыг чангатгах, малын гоц халдварт өвчний голомт тэлэхээс сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны сайд, Улсын байнгын онцгой комиссын штабын дарга С.Мэндсайхан, Дорноговь аймгийн Засаг дарга Л.Ишдорж нарт үүрэг болгосугай.

6."Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэрийн хорио цээрийн бүсэд устгасан малын нөхөх олговрыг тооцоход баримтлах үнийн ханш"-ийг хавсралтын ёсоор тогтоосугай.

7.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" Засгийн газрын 2000 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 62 дугаар тогтоолын 8, 9 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий
сайд Р.АМАРЖАРГАЛ**

**Байгаль орчны
сайд С.МЭНДСАЙХАН**

Засгийн газрын 2000 оны 70
дугаар тогтоолын хавсралт

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛААНБАДРАХ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХОРИО ЦЭЭРИЙН БҮСЭД УСТГАСАН МАЛЫН НӨХӨХ ОЛГОВРЫГ ТООЦОХОД БАРИМТЛАХ ҮНИЙН ХАНШ

Малын төрөл	Малын ялгаа	Хүйс	Үнийн ханш /мян. төг/
Тэмээ	Буур		150,0
	4 ба түүнээс дээш насны	эр	115,0
		эм	110,0
	3 наст	эр	70,0
		эм	65,0
	2 наст	эр	55,0
		эм	50,0
	1 наст	эр	45,0
эм		42,0	
Ботго		25,0	
Үхэр	Бух		130,0
	4 ба түүнээс дээш насны	эр	110,0
		эм	95,0
	3 наст	эр	85,0
		эм	85,0
	2 наст	эр	70,0
		эм	72,0
	1 наст	эр	32,0
эм		35,0	
Тугал		20,0	
Хонь	Хуц		35,0
	Нас гүйцсэн	эр	22,0
		эм	20,0
	1 наст	эр	14,0
		эм	12,0
Хурга		5,0	
Ямаа	Ухна		27,0
	Нас гүйцсэн	эр	17,0
		эм	15,0
	1 наст	эр	10,0
		эм	9,0
ИШИГ		4,0	



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 5 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Тогтоолуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 263 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд "Газрын харилцаа, хот байгуулалтын газар" гэсэн "с" заалт, "Бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 108 дугаар тогтоолын 2 дугаар зүйлд "Хөрөнгө оруулалт, хот тохижилтын газар" гэсэн "о" заалтыг тус тус нэмсүгэй.

2.Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг 30 (үйлчилгээний орлогоос цалинждаг болон нормативаар ажиллах орон тоо орохгүй) хүртэл хүнтэй байхаар тогтоосугай.

3.Газрын харилцаа, хот байгуулалтын газар, Хөрөнгө оруулалт, хот тохижилтын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоон мөрдүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболдод зөвшөөрсүгэй.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 108 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "а", "б", 2 дугаар зүйлийн "к" заалт болон 3 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий

сайд

Р.АМАРЖАРГАЛ

Хууль зүйн сайд

Д.ГАНБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 5 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагын оролцоо, гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, салбарын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон заавар, журмыг боловсруулан батлуулж, мөрдүүлэхийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонин, Сангийн сайд Я.Очирсүх нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий

сайд

Р.АМАРЖАРГАЛ

1."Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын

сайд

С.СОНИН

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР****Нэг.Хөтөлбөрийн үндэслэл**

Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн бүх салбарт явагдаж байгаа өөрчлөлт, шинэчлэлтийн үйл явц эрүүл мэндийн салбарыг нэгэн адил хамарч байна. Эрүүл мэндийн салбарын өөрчлөлт, шинэчлэлтийн тулгуур зорилтуудын нэг нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагын оролцоо, гүйцэтгэх үүргийг өргөжүүлж, өмчийн олон хэвшилд суурилсан эрүүл мэндийн салбарын тогтолцоог бүрдүүлэх явдал юм. Энэхүү тогтолцоог бүрдүүлэхдээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний онцлог, түүний чанар, хүртээмжийг харгалзсан уян хатан бодлого баримталж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага үүсэн хөгжих таатай орчинг бий болгохын зэрэгцээ хувьчлалын хамгийн оновчтой хэлбэрийг сонгон авч хэрэгжүүлэх юм.

1997 оноос эхлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх туршилтыг хэрэгжүүлж, эхний үе шат дуусч байна. Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 160, 218 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарын хувьчлалын үндсэн хэлбэр эмнэлгийн байгууллагын удирдлагыг гэрээгээр гүйцэтгүүлэх туршилтыг явуулав. Энэ ажлын хүрээнд дүүргийн нэгдсэн эмнэлэг, зарим сумдын эмнэлгийн удирдлагын үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллага болон иргэдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх журам, гэрээний загварыг боловсруулан туршилтын үйл ажиллагааг зохион байгууллаа.

Нийслэлд Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг, орон нутагт 16 аймгийн 47 сумын эмнэлгийн удирдлагын үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлэх

туршилт явагдав. Энэхүү туршилт нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, салбарын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн бөгөөд цаашид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхэд анхаарах асуудал, баримтлах зарчмыг тодорхойлоход чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

Хүн амд үзүүлж буй эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, эдийн засгийн үр өгөөж хангалтгүй байгаа өнөөгийн нөхцөлд эрүүл мэндийн салбарын хязгаарлагдмал хөрөнгө, нөөцийг үр дүнтэй ашиглах, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын удирдлагын арга барил, хариуцлагыг сайжруулах замаар тусламж, үйлчилгээний чанарыг зохих түвшинд хүргэж сайжруулах шаардлагатай байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эмч, эмнэлгийн ажиллагсад, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар шударга өрсөлдөөний үндсэн дээр гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг үргэлжлүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчин, санхүүжүүлэх механизмыг бүрдүүлэх зайлшгүй шаардлагаас үүдэн энэхүү хөтөлбөрийг боловсрууллаа.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай багц хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, энэхүү хөтөлбөрийг мөрдлөг болгоно.

**Хоёр.Хөтөлбөрийн зорилт,
хэрэгжүүлэх зарчим**

1. Эрүүл мэндийн тусламж,



үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхэд төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага болон иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, салбарын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилт оршино.

2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дор дурдсан зарчмыг баримтална:

а/шалгаруулалтыг ил тод, шударга өрсөлдөөний үндсэн дээр явуулах;

б/эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг нийгмийн гишүүн бүр хүртэх боломжтой байх нөхцөлийг бүрдүүлэх;

в/эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон анхан шатны тусламжийг бэхжүүлэхэд дэмжлэг болох;

г/төсөвт зардлыг хэмнэх, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх эрмэлзлэлийг төрүүлэхэд чиглэгдэх;

д/нэг шатлалд эмнэлгийн тусламж, үйлчилгээг ижил нөхцөлд үзүүлж байгаа байгууллагын хувьд гэрээний нөхцөл адил байх;

е/эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, эмчилгээний стандарт, үнэ тариф нь төрийн хяналт, зохицуулалттай байх;

ж/эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өнөөгийн түвшин, чанарыг бууруулахгүй байх, тусламж, үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчлэх хүрээг хэвээр хадгалах, түүнийг цаашид сайжруулах.

Гурав.Хөтөлбөрийн хамрах хүрээ

3.Хөтөлбөрт төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын дараахь тусламж, үйлчилгээ хамрагдана:

а/анхдагч шатлалын тусламж, үйлчилгээ буюу ерөнхий мэргэжлийн тусламж, үйлчилгээ:

Багийн, өрхийн, сумын болон сум дундын эмнэлгийн тусламж, үйлчилгээ хамаарна;

б/хоёрдогч шатлалын тусламж, үйлчилгээ буюу үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ:

Аймгийн болон дүүргийн нэгдсэн эмнэлгийн үйлчилгээ, тэдгээртэй дүйцэх түвшний ор бүхий эмнэлгийн (төрөх газрууд г.м) үйлчилгээ хамаарна;

в/гуравдагч шатлалын тусламж, үйлчилгээ буюу төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ:

Улсын хэмжээний үйлчилгээтэй клиникийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн тусламж, үйлчилгээ хамаарна.

Дөрөв.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, арга, хэлбэр

4.Хөтөлбөрийг 2000 оноос эхлэн хэрэгжүүлэх бөгөөд дараахь аргыг хэрэглэнэ:

а/тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх:

Эмнэлгийн удирдлага тодорхой үйлчилгээг гэрээний үндсэн дээр аж ахуйн нэгж, иргэнээр гүйцэтгүүлэх бөгөөд ашгийн тодорхой хувийг эмнэлэг авна. Аж ахуйн нэгж, иргэн нь тухайн үйлчилгээг стандартын түвшинд чанартай гүйцэтгэх үүрэг хүлээх бөгөөд эмнэлгийн удирдлага нь яам болон нутгийн захиргааны байгууллагын өмнө гэрээгээр гүйцэтгүүлж байгаа үйлчилгээний эцсийн үр дүнгийн талаар хариуцлага хүлээнэ. Лабораторийн шинжилгээ, дүрслэл оношилгоо болон угаалга, ариутгал, цэвэрлэгээ, гал тогоо зэрэг эмнэлгийн туслах үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлнэ;

б/удирдлагын /менежментийн/ гэрээ:

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн



захиргааны байгууллага нь эрүүл мэндийн байгууллагыг удирдах үйл ажиллагааг удирдлагын өндөр мэргэшил, дадлагатай, хөрөнгө, нөөцийг үр ашигтай зохион байгуулах чадвартай хувь хүн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

Менежментийн гэрээний үндсэн нөхцөл нь зардлаас давсан орлогыг тухайн эмнэлгийн хөрөнгө оруулалт, эмнэлгийн менежментийг сайжруулах, урамшуулахад зарцуулах явдал юм. Энэхүү хувь, хэмжээг төрийн захиргааны төв байгууллагаас тогтоох бөгөөд удирдлагын гэрээнд тодорхой тусгаж өгнө. Зардлаас давсан орлогоос эмнэлгийн удирдлагад олгох хувь нь эмнэлгийн үйл ажиллагааг хамгийн үр ашигтай байдлаар зохицуулах хөшүүрэг болох юм.

Менежментийн гэрээ нь аль болох бага зардлаар стандартын шаардлага хангасан эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар зардал хэмнэж, ашигтай ажиллах сонирхлыг урамшуулахад чиглэгдэнэ.

5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэл бүрийн онцлогт тохирсон хэлбэрийг сонгоно.

а/өрхийн эмнэлэг:

Өрхийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлнэ. Өрхийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг нэг иргэнд ногдох зардлын хэмжээ болон бүртгүүлсэн иргэдийн дундаж тоонд үндэслэн төр хариуцан санхүүжүүлнэ;

б/сумын эмнэлэг:

Сумын эмнэлгийн удирдлагатай сумын Засаг дарга, аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нар гурвалсан гэрээ байгуулж ажиллана;

в/аймаг, дүүргийн болон клиникийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд:

Эмнэлгийн удирдлагын үйл ажиллагаа, үндсэн болон туслах үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх арга

хэлбэрийг хэрэглэнэ.

Тав.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны байгууллагууд дараахь үүргийг гүйцэтгэнэ:

а/төрийн захиргааны төв байгууллага /Сангийн яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам/:

1/Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлон, холбогдох заавар, журам боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулах;

2/Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх эрх олгох, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хяналт тавих, шалгуур үзүүлэлтийг боловсруулах;

3/Тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллагын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, эмчилгээний стандартын мөрдөлтөд мэргэжлийн хяналт тавьж ажиллах;

4/Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхтэй холбоотой асуудлаар мэргэжил, арга зүйн дэмжлэг, тусалцаа үзүүлэх;

5/Удирдлагыг гэрээгээр гүйцэтгүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг /төсвийн болон даатгалын/ хугацаанд нь олгох.

б/Төрийн өмчийн хороо:

1/Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, түүнийг сайжруулах ажлыг зохион байгуулан гүйцэтгэлийг хянах;

2/Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулан удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавих;

3/Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэхээр шалгарсан гүйцэтгэгч аж ахуйн нэгж,



иргэнтэй төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах талаар гэрээ байгуулан хэрэгжилтэд нь хяналт тавих.

в/Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга:

1/Орон нутагт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн шатны Засаг дарга нь холбогдох газруудтай хамтран зохион байгуулж, түүнд хяналт тавих;

2/Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэхээр шалгарсан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, иргэнтэй гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах;

3/Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өнөөгийн түвшин, чанарыг бууруулахгүй байх, эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг цаг хугацаанд нь олгох арга хэмжээг авах;

4/Эрүүл мэндийн болон бусад салбар, аж ахуйн нэгж, хамт олон, хувь хүн, олон нийтийг хүн амын эрүүл мэндийг хамгаалах, сайжруулах ажилд өргөнөөр татан оролцуулж, тэдний үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах.

Зургаа.Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

7.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрсэн байна:

а/эмнэлгийн байгууллагын удирдлага нь эмнэлгийн төсөв, хөрөнгө, нөөцийг хэрхэн үр ашигтай зарцуулахыг өөрсдөө мэдэж шийддэг байх;

б/эмнэлгийн эмчилгээ, үйлчилгээний ажил хэвийн явагдах, үйлчлүүлэгчийн эрх,

ашгийг хамгаалах, тэдний эрэлт, хүсэлтэд нийцсэн үйлчилгээ үзүүлэх, оношилгоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмжийн ашиглалт, хангамж сайжирч, санхүү, аж ахуйн хувьд эмнэлгийн үйл ажиллагааг илүү үр дүнтэй явуулах нөхцөл бүрдэх;

в/эмнэлгийн удирдлагын багийн гишүүд болон эмч, ажилтнуудын ажлын хариуцлага, идэвхи, санаачилга дээшилж, хүнд үйлчлэх, ажилдаа хандах дадал заншил, сэтгэлгээнд нааштай өөрчлөлт гарах;

г/үйлчлүүлэгч /өвчтөн/ нь эмч болон эмнэлгээ өөрөө сонгох боломжтой болох, эмч, эмнэлэг нь чанартай сайн үйлчилгээгээр өвчтөнийг өөртөө татахын төлөө өрсөлдөх;

д/эрүүл мэндийн байгууллагын бүтэц, ажиллагсдын орон тоо нь тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээгээр зохицуулагдаж байвал зохих түвшинд хүрэх бөгөөд өрсөлдөөний дүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэх.

8.Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

а/эмнэлгийн тусламж, үйлчилгээний шатлалаар хүн амд үзүүлэх зайлшгүй шаардлагатай багц үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн байх;

б/эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, оролцоо нэмэгдсэн байх;

в/эрүүл мэндийн салбарт шударга өрсөлдөөн өрнөх нөхцөл, боломж бүрдсэн байх;

г/эрүүл мэндийн байгууллагын хөрөнгө, нөөцийн ашиглалт, санхүүгийн бие даасан байдал сайжирсан байх.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэл хэргэлт хэвлэл.

☎ 329487